

ЧИНГЭЛТЭЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

**НИЙСЛЭЛИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН 2025 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 13-НЫ ӨДРИЙН ШУУРХАЙ ЗӨВЛӨГӨӨН ДЭЭР
НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТ**

2025 оны 01 дүгээр сарын 16

Улаанбаатар хот

Д/д	Үүрэг, даалгаврын дагуу хийж хэрэгжүүлсэн үйл ажиллагаа	Үүрэг, даалгавар биелүүлээгүй шалтгаан	Цаашид авч хэрэгжүүлэх арга зам	Хувь
Үүрэг, даалгавар НЭГ: 2025 оны эхнээс төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг жигд ханган, орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, бааз суурийг өргөтгөх чиглэлээр тодорхой ажил зохион байгуулж ажиллах.				
1	2025 оны дүүргийн төсвийн орлого бүрдүүлэх ажлыг эрчимжүүлж, төсвийн орлогын нэр төрөл бүрээр батлагдсан хуваарийн дагуу жигд ханган биелүүлэх, татварын бааз суурийг өргөжүүлэхээр Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч П.Сайнзоригийн 2024 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн “Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд үл хөдлөх хөрөнгийг бүртгэж тоолох, татварт хамрагдалтыг сайжруулах, төсвийн орлогын нэмэлт эх үүсвэрийг бүрдүүлэх” ажлын удирдамж, ажлын төлөвлөгөөний дагуу хорооны нутаг дэвсгэрт шинээр Үл хөдлөх эд хөрөнгө бүртгэх, мэдэгдэх хуудас болон ажлын байранд очин ажиллах, татварын ертэй иргэдэд нэхэмжлэх болон масс мессеж хүргүүлэх, урьд оны болон тайлант оны өр барагдуулах процесс ажиллагааг хууль тогтоомжийн дагуу шат дараалан ажиллагаа хийж, татвар төлөгчдөд татварын тайлан, төлбөр төлөх зэрэг зөвлөгөө мэдээлэл өгөхөөр зурагт хуудас, дүрс бичлэг хийхээр төлөвлөж байна.	-	Хэрэгжилтийг ханган үйл ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	70
Үүрэг, даалгавар ТАВ: Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын хүрээнд газар чөлөөлөх ажлуудын бэлтгэл ажлыг сайтар зохион байгуулах.				
2	Чингэлтэй дүүргийн нутаг дэвсгэрт иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, газар ашиглалтыг сайжруулах, явган хүний зам, талбайн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх, авто замын түгжрэлийг бууруулах зорилтын хүрээнд газрын зөрчил арилгах, газар чөлөөлөлтийн ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулж байгаатай холбоотойгоор 2025 оны зөрчил арилгах арга хэмжээний хүрээнд гэр хорооллын газар	-	Хэрэгжилтийг ханган үйл ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	70

	<p>болон зуслангийн бүсээс бусад Улаанбаатар хотын орон сууцны хороолол дундах автомат хаалт болон бусад орц гарц хаасан хаалт, шон, хашаа, хайс зэрэг зөрчлийг хээрийн болон суурин судалгаагаар нарийвчлан гаргаж Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны Кадастрын хэлтэст цахимаар хүргүүлсэн. Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын нөлөөлөлд өртөх 13 саналыг Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанд, дүүргийн Газар зохион байгуулалтын албаны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгахаар 38 саналыг тус тус хүргүүлсэн. Газар чөлөөлөх ажлыг 2025 оны 03 дугаар сард эхлүүлэхээр ажиллаж байна.</p>			
<p>Үүрэг, даалгавар ДОЛОО: Нутгийн захиргааны байгууллагууд ажилтан, албан хаагч, удирдах албан тушаалтнуудын сахилга, хариуцлагыг өндөржүүлж, ажлын цаг ашиглалт, бүтээмжийг сайжруулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.</p>				
3	<p>Албан хаагчдын цагийн бүртгэлийг цаг бүртгэлийн системээс татан авч, удирдлагад танилцуулан ажиллаж байгаа бөгөөд Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс дүүргийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын цаг ашиглалтын үзүүлэлтэд сар бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хяналт тавин ажиллаж байна. Албан хаагчдын ажлын бүтээмжийг сайжруулах зорилгоор хэрэгцээтэй байгаа сургалтыг тодорхойлж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн төвтэй хамтран сар бүр холбогдох сургалтуудад хамруулан ажиллаж байна. Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл үр дүн, мэргэшлийн түвшнийг үнэлэх журмын дагуу албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хагас, бүтэн жилээр үнэлэн ажиллаж байна. Албан хаагчдын сахилга, хариуцлагыг өндөржүүлэх зорилгоор зөрчил гаргасан албан хаагчдад тухай бүр мэдэгдэл хүргүүлэх, сануулах, цалингийн хувь бууруулах зэрэг сахилгын шийтгэл ногдуулж байгаа бөгөөд ёс зүйн болон сахилгын зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалтуудыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.</p>			100
<p>Үүрэг, даалгавар НАЙМ: Нутгийн захиргааны байгууллагууд өргөдөл, гомдол, албан бичгийг бүх талаас нягтлан судалж, хууль зүйн үндэслэлтэйгээр эцэслэн шийдвэрлэж, хуулийн хугацаанд иргэнд хариу өгөх, хариуцлагагүй хандсан албан хаагч болон удирдлагад хариуцлага тооцож ажиллах.</p>				
	<p>Чингэлтэй дүүргийн хэмжээнд 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 01 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд нийт 121 өргөдөл ирснээс 70 өргөдлийг эцэслэн шийдвэрлэж, хариуг тухай бүр мэдэгдсэн ба судлагдах шатанд 51 өргөдөл байна.</p>			

4	<p>Дүүргийн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 4 хоног 9 цаг 22 минут байна. Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, зөрчлийн мэдээг хянаж, долоо хоног бүрийн Лхагва гаригт нэгтгэн, Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэн ажиллаж байна. Дүүргийн хэмжээнд 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 01 дүгээр сарын 08-ны өдрийг хүртэлх хугацаанд зөрчил гаргасан дүүргийн Эрүүл мэндийн төвд 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн Засаг даргын Тамгын газрын даргын 3/79 дугаартай албан бичгийг хүргүүлж, анхаарч ажиллах чиглэл хүргүүлсэн. Мөн дүүргийн хэмжээнд 2025 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 01 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд нийт 308 албан бичиг ирснээс, 214 албан бичгийг эцэслэн шийдвэрлэсэн ба судлагдах шатанд 94, шийдвэрлэлтийн дундаж хугацаа 5 хоног байна.</p> <p>2025 оны үйл ажиллагааны хүрээнд хуулиар хүлээсэн үүрэг, эрхэлсэн ажилдаа зөрчил дутагдал гаргасан албан хаагч болон удирдах албан хаагч нарт байгууллагын дүрэм, журам, холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцохыг анхаарч ажиллах чиглэл өгсөн.</p>			100
<p>Үүрэг, даалгавар ЕС: Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд чиг үүргийнхээ хүрээнд хийж хэрэгжүүлж буй ажлын тайлан, судалгаа, тоон мэдээ мэдээлэл болон удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тайлагнаж ажиллах.</p>				
5	<p>Дүүргийн Засаг даргын Тамгын газар нь Нийслэлийн удирдах ажилтнуудын ээлжит шуурхай зөвлөгөөн дээр Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчаас өгсөн үүрэг даалгаврыг холбогдох хэлтэс албадад хүргүүлж, биелэлтийг нэгтгэн Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээр хянуулж, нэгтгэлийг заасан хугацаанд тайлагнаж, Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын Ulaanbaatar.ERP системд байршуулан ажиллаж байна. Мөн хэлтэс, албадын чиг үүргийн хүрээнд хийж хэрэгжүүлж буй ажлын тайлан, судалгаа, тоон мэдээ мэдээллүүдийг тогтоосон цаг хугацаанд тухай бүр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тайлагнан ажиллаж байна.</p>			100
<p>Үүрэг, даалгавар АРАВ: Нийслэлийн байгууллагууд иргэд, олон нийтэд төрийн үйлчилгээ үзүүлэхдээ хүнд суртал, чирэгдэл, ёс зүйн доголдол гаргахгүй үйлчлэх, зөрчил гаргасан албан хаагчдад хариуцлага тооцох, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.</p>				
6	<p>Чингэлтэй дүүргийн Засаг даргын Тамгын газар нь иргэд, олон нийтэд төрийн үйлчилгээ үзүүлэхдээ хүнд суртал, чирэгдэл, ёс зүйн доголдол гаргахгүй үйлчлэхэд тогтмол хяналт тавин ажиллаж байна. Ажил үүрэгтээ хариуцлагагүй хандсан ёс зүйн хэм хэмжээний зөрчил гаргасантай холбоотой 2024 оны үйл ажиллагааны хүрээнд 9 өргөдөл, гомдол</p>			100

	ирсэн ба холбогдох албан хаагчид сонсох ажиллагаа явуулахаар мэдэгдэх хуудас хүргүүлж, хариу тайлбарыг авч сонсох ажиллагааг зохион байгуулж, 5 албан хаагчид “Сануулах” сахилгын шийтгэл ногдуулж, 2 албан хаагчид цалингийн 20 хувь бууруулах арга хэмжээг авч нийт албан хаагчдад хуулиар хориглосон болон байгууллагын дотоод журмаар тогтоосон хэм хэмжээг мөрдөн ажиллаж, төрийн албаны ёс зүйн хэмжээг дээшлүүлэн ажиллах тухай үүрэг чиглэлийг тус тус өгсөн.			
Үүрэг, даалгавар АРВАН НЭГ: Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд албан хаагч бүр ажил, албан тушаалаа хэрэгжүүлэхдээ авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хуулийн хориглолт хязгаарлалтыг зөрчихгүй байхад анхаарч ажиллах.				
7	Төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдтэй байгуулах гэрээний төсөлд “Авилгалаас урьдчилан сэргийлэх” асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, хууль зүйн хүрээнд нийцүүлэн боловсруулахад арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх, холбогдох хуулийн үндэслэл, заалтыг судлах, гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг дүгнэсэн байдалд хяналт тавих ажлыг зохион байгуулан холбогдох хэлтэс, албатай хамтран ажиллаж байна. Авлига үүсэх эрсдэлийг бууруулах чиглэлийн хүрээнд Авлигатай тэмцэх газраас зохион байгуулдаг “Авлигын эсрэг хамтдаа” сургалтад 2024 оны 05 дугаар сарын 27-ны өдөр дүүргийн Засаг даргын Тамгын газрын албан хаагчид болон 24 хороодын албан хаагчдыг бүрэн хамруулж, 2025 оны үйл ажиллагааны хүрээнд албан хаагчдыг сургалтад хамруулж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулахаар ажиллаж байна.	-	Хэрэгжилтийг ханган үйл ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	70
Үүрэг, даалгавар АРВАН ГУРАВ: Нийслэлийн Удирдах ажилтнуудын Шуурхай зөвлөгөөнөөс өгсөн бүх үүрэг даалгаврын хэрэгжилтийг тайлагнаж, танилцуулах. /2024 оны жилийн эцсийн байдлаар/				
8	Нийслэлийн Удирдах ажилтнуудын 2024 оны шуурхай зөвлөгөөнд Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчаас өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар нэгтгэн гаргаж, 2025 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын ахлах мэргэжилтэнд Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын Ulaanbaatar.ERP системээр тайлагнан ажилласан.			100
Үүрэг, даалгавар АРВАН ДӨРӨВ: Дүүргүүд өөрсдийн нутаг дэвсгэрийн гудамж, зам талбайн халтиргаа гулгаа үүсэхээс сэргийлж, цас орсон тухай бүр нь цаг хугацаа алдалгүй ажлаа шуурхай зохион байгуулж, хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллах.				
9	Чингэлтэй дүүргийн хот нийтийн аж ахуйн чиглэлээр ажиллаж буй “Чингэлтэй тохижилт үйлчилгээ” ХХК, “Найши трейд” ХХК-иуд бэлэн байдлыг ханган, хариуцсан бүсүүдэд	-	Хэрэгжилтийг ханган үйл	70

	<p>шуурхай арга хэмжээг авч ажиллаж байна. Зам талбайн тохижилт, цэвэрлэгээ хариуцсан 2 байгууллагын нийт зам талбайн үйлчлэгч 155, жолооч 25, давс бодис цацах тусгай зориулалтын 9 автомашин, зам талбайн шүүрдэгч тусгай зориулалтын 9 автомашин, экскаватор 2, ковш 2, бобкат 2, бичил техник хэрэгсэл 8, нийт 32 техник хэрэгсэлтэйгээр хариуцсан авто замын зорчих хэсгийн халтиргаа гулгааг арилган ажилласан. Гэр хорооллын өгсүүр, уруу чулуун зам, төв зам, байшин хорооллын дундах авто замууд, төвийн бүсийн томоохон гол гудамж зам талбай, зуслангийн бүсийн авто замуудад цас орсон даруйд шуурхай арга хэмжээ авч давс бодисыг тухай бүр цацан ажиллаж байна. 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн байдлаар 1872 тонн бодис, 390.5 тонн давс, 511м³ дайргын нөөцтэй байна.</p>		ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	
<p>Үүрэг, даалгавар АРВАН ТАВ: Сэлбэ дэд төвийн хүрээнд газар чөлөөлөлтөөс үлдсэн хог хаягдлыг цэвэрлэх ажлыг шуурхай зохион байгуулах.</p>				
10	<p>Улаанбаатар хотын хэт төвлөрлийг задлах, агаар орчны бохирдлыг бууруулах “20 минутын хот” зорилтын хүрээнд "Сэлбэ хороолол"-ыг байгуулах, орон сууцжуулах ажил дүүргийн 14, 18 дугаар хороодын нутаг дэвсгэрт эхэлсэн ба эхний 800 гаруй нэгж талбарыг бүрэн чөлөөлөн ажилласан байна. Тус чөлөөлөгдсөн гудамж талбайд үүсмэл болон барилгын хог хаягдал ихээр үүсэж, нүхэн жорлон, муу усны нүхний үнэр нь агаар болон хөрсний бохирдлыг үүсгэж, буулгасан нуранги байшингуудад орон гэргүй иргэд орогнох, эд зүйл хулгайлах, гэмт хэргийн шинжтэй үйлдэл гаргах зэрэг олон асуудлууд үүсээд байна. Иймд барилгын хог хаягдлыг ачиж тээвэрлэх, гудамж, зам, талбайн цэвэрлэгээ, төсөл хэрэгжих талбайг түр хашаа барих, төслийн ерөнхий төлөвлөлтийг олон нийтэд сурталчлах ажлыг яаралтай эхлүүлж иргэд, оршин суугчдад ээлтэй орчин бүрдүүлэх ажлын хүрээнд шаардагдах төсвийг судлан боловсруулж, дэмжин ажиллах тухай Дүүргийн засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн 01/69 тоот албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэн ажилласан.</p>	-	Хэрэгжилтийг ханган үйл ажиллагааг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	70
ҮНЭЛГЭЭНИЙ ДУНДАЖ			85.0%	

ТАНИЛЦСАН:
ЗАСАГ ДАРГА

Н.МАНДУУЛ

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА

Ж.ЛХАГВАСҮРЭН

НЭГТГЭЛИЙГ ХЯНАСАН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Л.БАЯРМАА

ҮНЭЛГЭЭГ ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА

Э.БУЯН-ӨЛЗИЙ

ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
НИЙСЛЭЛ, ДҮҮРГИЙН ШУУРХАЙН БИЕЛЭЛТ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

Ц.БАЛЖИННЯМ

НЭГТГЭСЭН:
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

В.УРАНЧИМЭГ